



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 1109

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол шинжлэх ухааны яамнаас эрх шилжиж ирсэн Цэцэрлэгийн барилга 150 ортой /Жаргалант сум, Бичигт баг/ барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд: Б.Далайбаяр - Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
Ж.Батлхагва - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Ц.Соёлмаа - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Б.Даваадорж)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Дариймаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

8400 03 0084

D/Tush-A/09-Bo